МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/38 Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001: 2016 стандартыг нэвтрүүлсэнд хөндлөнгийн баталгаажуулалтын аудит хийх зардалд 15.6 сая /Арван таван сая зургаан зуун мянган / төгрөгийг зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулагдах 15.6 сая төгрөг /Арван таван сая зургаан зуун мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 5.29-д заасан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/ -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

02 01 D/Zax-A/38-Da